

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

.....

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“УЛЗ ГРУПП” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

А.БҮРЭНТОГТОХ

**“УЛЗ ГРУПП” ХХК-ИЙН АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ
ХЭРЭГЖИЖ БУЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ: MV-020442

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6183506

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

.....

БОЛОВСРУУЛСАН:

“УЛЗ ГРУПП” ХХК-ИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ч.БИЛГҮҮН

АГУУЛГА

1. ОРШИЛ	3
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2.1. 2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим	7
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3.1. Физик газарзүйн нөхцөл	8
3.2. Уур амьсгал.....	9
3.3. Агаарын чанар.....	9
3.4. Физик бохирдол, хог хаягдал	9
3.5. Геологийн тогтоц ба геоморфологи	10
3.6. Гадаргын болон газрын доорхи ус	10
3.7. Хөрсөн бүрхэвч	10
3.8. Ургамлан нөмрөг.....	10
3.9. Тусгай хамгаалалттай газар нутаг	10
3.10.Түүх соёлын өв.....	10
3.11.Нийгэм эдийн засгийн байдал.....	11
4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл....	11
4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	11
4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.	11
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	11
5.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
5.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
5.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	19
5.6. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
5.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
5.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21

5.9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
5.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	26

1. ОРШИЛ

“Алтан дорнод Монгол”ХХК-иас тусгай зөвшөөрлийн талбайг 2015 онд “Бат Бродерс” ХХК шилжүүлэн авсан бол “Улз групп”ХХК нь 2017 онд “Батбродерс” ХХК-иас MV-020442 тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан ба АРМИКО МАЙНИНГ КОРПОРАЦ ХХК нь 2024 оны 05 сарын 14 өдөр УЛЗ ГРУПП ХХК-иас шилжүүлэн авсан.

Тусгай зөвшөөрлийн талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд орж ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй байсан.

2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газрын 289 дүгээр тогтоолоор уг хуулийн үйлчлэлийн хүрээнд гарч “Бат Бродерс” ХХК нь 2016 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулан 5.3кг нөөцийг олборлон улсад тушаасан.

Талбайд Байгаль орчны, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яамнаас томилогдсон ажлын хэсэг ажиллаж усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоон, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу онцгой хамгаалалтын 50м бүс татан “Олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ”-г 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан.

Ордын нөөц нь онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй бөгөөд “Улз групп” ХХК нь тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаас хойш ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна. Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутагт үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүд алт угаасан шар усыг алдаж Орхон голд нийлүүлсэн, байгаль орчин бохирдуулснаас уг районд байх тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цуцалсан. “Улз групп” ХХК нь уг талбайд ямар нэгэн олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй болохоо Шүүхийн байгууллагаар нотлуулан тусгай зөвшөөрлийг 2021 онд сэргээсэн.

“Армико майнинг корпорац” ХХК нь 2022 оноос уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа стандарт, журам, Монгол улсад мөрдөгдөж буй хуулийн дагуу эрхлэн явуулахаар “Өлийн гол” алтны шороон ордын ТЭЗҮ-ийн тодотголыг “Идэр Мөнх арвижих” ХХК боловсруулсан. БОННУ -ний тодотгол тайланг байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Их зос” ХХК боловсруулсан.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн талбайн MV-020442 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь, засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт "Өлийн гол", нэртэй газар харъяалагдана. Томоохон хот суурин болох Улаанбаатар хот ба Хархорин сумын төв нь хайгуулын талбайгаас 540 ба 130 км-т тус тус байрлах ба хатуу хучилттай авто замаас 60 км зайд байрлана.

Топопланшет L-47-48. "Бодонтын ам" алтны шороон ордын дүүрэгт жилийн аль ч улиралд автомашинаар зорчих боломжтой юм. Тус орд нь Архангай аймгийн Цэнхэр сумын төв


ба Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын төвөөс тус тус 60 км зайд оршино. Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбицолыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	101	43	0.6	47	0	1.7
2	101	39	15.6	47	0	1.68
3	101	39	15.64	46	59	1.67
4	101	41	8.87	46	59	1.66
5	101	41	3.27	46	59	3.42
6	101	40	53.55	46	59	6.39
7	101	40	44.01	46	59	9.81
8	101	40	34.11	46	59	11.55
9	101	40	15.41	46	59	16.99
10	101	40	5.34	46	59	18.68
11	101	39	57.39	46	59	19.32
12	101	39	46.81	46	59	18.15
13	101	39	15.64	46	59	18.98
14	101	39	15.64	46	59	22.28
15	101	39	46.53	46	59	21.39
16	101	39	57.29	46	59	22.58
17	101	40	6.19	46	59	21.87
18	101	40	16.91	46	59	20.07
19	101	40	35.64	46	59	14.62
20	101	40	45.72	46	59	12.86
21	101	40	55.61	46	59	9.31
22	101	41	5.23	46	59	6.37
23	101	41	20.19	46	59	1.66
24	101	41	25.64	46	59	1.66
25	101	41	25.64	46	59	1.31
26	101	41	50.99	46	58	49.4
27	101	42	16.08	46	58	40.45
28	101	42	14.13	46	58	44.37
29	101	42	19.22	46	59	3.1
30	101	42	2.64	46	59	15.75
31	101	41	56.37	46	59	19.7
32	101	41	49.9	46	59	22.45
33	101	41	43.18	46	59	26.15
34	101	41	38.78	46	59	29.56
35	101	41	31	46	59	38.93
36	101	41	30.75	46	59	39.36
37	101	41	30.73	46	59	39.87
38	101	41	30.9	46	59	40.22

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020442 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ
“ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

39	101	41	31.1	46	59	40.51
40	101	41	31.37	46	59	40.8
41	101	41	31.79	46	59	41.02
42	101	41	32.21	46	59	41.2
43	101	41	32.83	46	59	41.3
44	101	41	33.35	46	59	41.3
45	101	41	33.83	46	59	41.23
46	101	41	34.38	46	59	41.07
47	101	41	34.83	46	59	40.83
48	101	41	35.21	46	59	40.49
49	101	41	42.65	46	59	31.45
50	101	41	46.46	46	59	28.5
51	101	41	52.64	46	59	25.1
52	101	41	59.24	46	59	22.29
53	101	42	6	46	59	18.03
54	101	42	20.32	46	59	7.15
55	101	42	20.58	46	59	8.1
56	101	42	35.44	46	59	18.06
57	101	43	0.59	46	59	22.96
58	101	43	0.59	46	59	19.59
59	101	42	37.89	46	59	15.17
60	101	42	24.96	46	59	6.5
61	101	42	19.01	46	58	44.61
62	101	42	22.64	46	58	37.34
63	101	42	29.44	46	58	25.12
64	101	42	25.68	46	58	14.59
65	101	42	30.76	46	58	5.7
66	101	42	25.68	46	58	5.7
67	101	42	20.74	46	58	14.36
68	101	42	24.49	46	58	24.91
69	101	42	18.32	46	58	35.99
70	101	41	48.55	46	58	46.62
71	101	41	25.64	46	58	57.38
72	101	41	25.64	46	56	21.65
73	101	42	5.64	46	56	21.65
74	101	42	5.64	46	58	5.65
75	101	43	0.64	46	58	5.65
76	101	43	0.6	47	0	1.7



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

2.1. 2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим

2.1.1. Ажиллах горим

Өлийн гол шороон орд 2026 оны 04-р сараас эхлэн 10-р сарыг дуустал ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу тооцон ажиллахаар төлөвлөв.

2.1.2. 2026 онд явагдах уулын ажил

2026 оны ашиглалтын нийт хугацаанд 2889 мян.м³ хөрс хуулж, 437.96 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын итгэлцүүр 6.59 м³/м³ байна.

2.1.3. Үржил шимт хөрс хуулалт

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3- 0.6 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

2.1.4. Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил

Алт агуулсан элсний тогтоц тэгш тогтвортой, гүн бага зэрэг дотоод овоолгоор төлөвлөх таатай нөхцөл байгаа тул шимт хөрсийг түрж үүсэх карьер дагуу овоолж, ашиглагдсан хоосон орон зайг хөрсөөр нөхөн дүүргэлт хийж дотоод овоолго хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хамт хийнэ. Ил уурхайн хөрсийг олборлосон орон зайг дүүргэх зорилгоор дотоод овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн ажилд Tonly 875В маркийн 60 тн даацтай автосамосвал ажиллах ба тээвэрлэлтийн дундаж зай 1.0 км байна.

2.1.5. Элс олборлолтын ажил

Өлийн голны алтны шороон ордын элс шаварлаг их байгаа тул угаан баяжуулахад гүн болон нам дүүргэлтийн шлюз бүхий УГ-80 маркийн угаах төхөөрөмж ажиллаж шлихийн алтыг гаргана. 2026 онд нийт хугацаанд 0.360 гр/м³ агуулгатай 437.96 мян.м³ элсийг 90.2%-ийн металл авалттайгаар баяжуулж химийн цэврээр 120.57 кг (сорьц 764) алт үйлдвэрлэнэ.

2.1.6. Ус хангамж

Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь элс угаан баяжуулах цех, ажилчдын хотхон байна. Уурхайн усан хангамжийг ордын талбайд байрлах 241.5 мян.м³ эзлэхүүнтэй үүсмэл нуур болон шүүрэлтийн усыг хуримтлуулж хангана. Өлийн гол алтны шороон орд нь Өлийн голын хөндийн ай савд хамаарагддаг бөгөөд ордын талбайд хайгуулын ажил хийгдэх явцад гидрогеологийн судлагааг “Алтандорнод Монгол” ХХК 2005-2008 онд хийж гүйцэтгэсэн байна. Тус ордын усны түвшин харьцангуй бага зузаантай (2.1-8.2 м, дундажаар 4.2 м), газар доорх усны урсцын хэмжээ, усны түвшингийн хэлбэлзэл зэргийг харгалзан желонкын аргаар тодорхойлоход ордын дундажаар шүүрлийн хэмжээ 15.7 м³/цаг байсан байна.

Баяжуулах технологийн шат дамжлагаас гарах эфель болон галь дахь ус нь өөрийн урсгалаар тунаах даланд хуримтлагдан тунана. Тунаах даланд тунасан ус нь мөн адил цэвэршүүлэх даланруу өөрийн уурсгалаар орно. Мөн цэвэршүүлэх даланд ил уурхайгаас шүүрэх усыг татаж баяжуулах цехэд ашиглана. Технологийн тооцоогоор 1 м³ элс угаахад 4.33 м³ технологийн ус зарцуулна. Технологийн усны 79.9%-ийг дахин ашиглана.

2.1.7. Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.1.8. Шатах тослох материалын агуулах

ШТМ хадгалахад зориулж 50тн-ын ган сав 3 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

2.1.9. Сэлбэг материалын агуулах

Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.

2.1.10. Машины зогсоол

Уурхайн элс, хөрсний тээвэрлэлт, элс угаан баяжуулахад 3ш дизель генератор ороод нийт 13ш том оворын техник ашиглагдана.

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1. Физик газарзүйн нөхцөл

Монгол орны төв хэсэгт өргөн уудам нутгийг эзэлж байсан Заяын шавийн өмнөд хязгаар нь одоогийн Цэнхэр сумын нутаг байсан бөгөөд сумын ард иргэдийн дийлэнх нь Ачит гүний хошууныхан, Зоригт гүний хошууныхан байжээ. Цэнхэр сумыг анх байгуулахдаа Ачит гүний хошуунаас гадна бусад хошууны ард иргэдийг тус сумын бүрэлдэхүүнд оруулсан бөгөөд зүүн талаараа Илдэн бээлийн хошуу, зүүн хойт талаар нь Луу гүний хошуу цөөн тооны айл байсан бололтой. Цэнхэр сум нь Хангайн уулархаг муж хийгээд Орхон, Тамирын хөндийд оршдог бөгөөд баруун хойд талаараа Булган сум, хойд талаараа Эрдэнбулган, Батцэнгэл сумтай баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, өмнөд талаараа Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, зүүн өмнө зүүн талаараа өөрийн аймгийн Төвшрүүлэх, Хотонт сумтай хиллэн оршино.

3.2. Уур амьсгал

Өвөл: Архангай аймгийн нутагт дунджаар 10 дугаар сарын 28-с 11 дүгээр сарын 3-ны үед өвөл эхэлж, 3 дугаар сарын 21-27-ны үеэр дуусч нийтдээ 140-150 хоног үргэлжилнэ. Өвлийн саруудад цаг агаар гол төлөв цэлмэг тогтуун байдаг. Хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж агаарын температур $20-25^{\circ}\text{C}$ хүйтэн, үнэмлэхүй хамгийн бага нь $-40-44^{\circ}\text{C}$, Хангай, Тариат, Цахир сумдын нутгаар $-50-55^{\circ}\text{C}$ хүрч хүйтэрч байдаг. Энэ улиралд 5-6 мм хур тунадас унах ба харьцангуй чийгшил 50-58% байдаг байна.

Хавар: Архангай аймгийн нутагт 3 дугаар сарын 20-25-ны үед хавар эхэлж, 5 дугаар сарын 25-28 хүртэл 55-63 хоног үргэлжилдэг. Хоногийн дундаж температур түргэн нэмэгдэж 4 дүгээр сарын 9-15-ны үед бүх нутгаар 0°C -г давж дулаардаг. Агаарын даралт 826.6-846.0гПа болж өвлийнхөөс буурна. Салхины хурд хамгийн ихсэж 5-10 м/с болох бөгөөд заримдаа 24 м/с хүрдэг. Энэ улиралд хуурай өдрийн тоо ихсэж дунджаар 16.6-18.6, чийглэг өдрийн тоо эрс багасч 1.1-2.0 тус тус байна.

Зун: Аймгийн нутгаар зуны улирал 5 дугаар сарын 25-28-ны орчмоор эхэлж, 8 дугаар сүүлч, 9 дүгээр сарын 15-ны орчмоор төгсдөг. Зуны улирал нийтдээ 95-106 хоног үргэлжлэх боловч Хангай, Тариат, Цахир сумын уулархаг нутгаар харьцангуй богино 60-80 хоног үргэлжилнэ. Энэ улиралд хамгийн дулаан болж, хур тунадасны дийлэнх хэсэг ордог. Салхины хурд бусад улирлаас бага 1.6-3.6м/с байх бөгөөд уул хөндийн өдөр шөнөөр чиглэлээ сольдог салхи томоохон голын хөндий нутгуудаар ажиглагддаг.

Агаарын дундаж температур жилийн хамгийн дулаан 7 дугаар сард $14-20^{\circ}\text{C}$ байх бөгөөд нилээн өндөрлөг газар орших Тариатад сэрүүвтэр $12-20^{\circ}\text{C}$ байна. Үүлшлийн хэмжээ бусад улирлаас их байдаг. Нийт үүлшил дунджаар 6 балл, доод мандлын үүлшил 3.0-4.5 балл хүрдэг. Бүрхэг өдрийн тоо нийт үүлшлээр 6-15 хүрнэ. Зуны улиралд жилийн хур тунадас 6070% нь 83-92 мм хур тунадас унадаг.

Намар: Аймгийн нутгаар намрын улирал 8 дугаар сарын сүүлч 9 дүгээр сарын эхнээс, 10 дугаар сарын эцэс, 11 дүгээр сарын эхэн үе хүртэл нийтдээ 60 гаруй хоног үргэлжилнэ. Намрын эхэн үед хоногийн дундаж агаарын температур 9 дүгээр сарын 21-27-нд $+5$ градусын зайцыг, 10 дугаар сарын 20ны орчмоор 0°C -ын зайцыг тус тус дайрч хүйтэрдэг. Салхины хурд 2.0-3.5 м/с болж зуны улирлаас эхэлдэг. Хур тунадасны хэмжээ намрын эхний сард 24-30 мм, сүүлийн сард 8-10 мм болж эрс буурдаг. Харьцангуй чийгшил алгуур багасч 60-54%, усны уурын даралт 3.4гПа болно. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 15-22-ны үед орж 9 дүгээр сарын 25-31-ны үед цасан бүрхүүл үүсэн тогтож эхэлнэ.

3.3. Агаарын чанар

Агаарын чанарын хэмжилтийг 2025 он 08 дугаар сарын 26-ны өдөр төслийн талбайд хийж гүйцэтгэсэн. Уг хэмжилтээр Хүхэрлэг хий (SO_2), Азотын давхар исэл (NO_2), Нийт тоос (TSP), Дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн дүнгээр Агаарын чанарын стандарт MNS4585:2016-аас давсан үзүүлэлт байхгүй байна.

3.4. Физик бохирдол, хог хаягдал

Төслийн талбайд уурхайн ажилчдын байр засварын газрын ойролцоо орчны газрын гадарга, хөрсөн бүрхэвч ахуйн шингэн болон хатуу хог хаягдал болон уурхайн тээвэр

олборлолтын үйл ажиллагаанаас хүчтэй эвдрэл элэгдэлд орж орчны доройтол ихээр үүссэн байна. Уурхайн үйл ажиллагаанд бэлтгэх зорилгоор ургамал болон хөрсний өнгөн хэсгийн хуулалт, хөрс хуулалт, буцааж булах үйл ажиллагаа, тээвэрлэлт болон хаягдал байршуулах зэрэг үйл ажиллагаанаас агаарт тоосжилт их хэмжээгээр үүсэх, алт угаах үйл ажиллагаа, шигшиж, бутлах үйл ажиллагаа зэргээс их хэмжээний дуу чимээ үүсэх, хог хаягдлын хадгалалтаас агаар, хөрс орчинд үнэр үүсэх бохирдлууд байна.

3.5. Геологийн тогтоц ба геоморфологи

"Өлийн гол-1" алтны шороон орд нь Монгол-Агнуурын атираат бүсийн Хангайн атираат дүүргийн зүүн өмнөд хэсэгт палеозойн ба бага хэмжээгээр кайнозойн хурдасаас тогтож оршино. Металлогенийн ангилалын хувьд энэ талбай нь Өлзийт тээлийн хүдрийн-шороон алтны дүүргийн хойд хагаралд байрлана. Тогтоцын хувьд хайгуул хийсэн орд Хангайн зүүн структур-формацын бүсэд хамаарна.

3.6. Гадаргын болон газрын доорхи ус

MV-020442 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь Орхон голын сав газарт хамаарна. Орхон голын сав газар нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужид багтаж байгаа ба голын эхэн хэсэг нь Хангайн гол нурууны тойрогт, дунд ба адаг хэсэг нь Сэлэнгэ, Орхоны сав газрын дундаж өндөр уулсын тойрогт хамрагдаж байна.

3.7. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд уулын хар хүрэн хөрс тархсан байна.

3.8. Ургамлан нөмрөг

Ургамалжилтын судалгааны үр дүнд төслийн талбай түүний орчимд ландшафтын онцлогоос (д.т.д 2153-2300) хамаарах өндөр уулын ойт хээрийн **Шинэсэн ой, Ботуульулалж-алаг өвст** болон **Боролзгоно-Ботууль-алаг өвст болон бүлгэмдлүүд** тархсан байна.

Амьтны аймаг

Төслийн талбай нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалын хувьд Хангайн тойрогт багтана.

3.9. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайн ойр орших тусгай хамгаалалттай Хангайн нуруу Байгалийн цогцолборт газар, Хүйсийн найман нуур Дурсгалт газар байрлаж байна.

3.10.Түүх соёлын өв

“Армико майнинг корпорац” ХХК-ийн төсөл хэрэгжих MV-020442 тоот тусгай зөвшөөрөлтэй 1417.06 га талбайд болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй байна. Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомж буюу МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Цэнхэр сумын засаг захиргааны байгууллага, ШУА, Палеонтологийн хүрээлэн /70118283/, Түүх угсаатны зүйн хүрээлэн /11-458305/-д нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

3.11. Нийгэм эдийн засгийн байдал

Нийгэм эдийн засгийн хувьд уг төсөл хэрэгжсэнээр нийт 207 хүнийг ажлын байраар хангах, улс орон нутгийн төсөвт татвар хураамж төлөх зэргээр эерэг нөлөөтэй байна.

4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Улз групп” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “Өлийн гол 1” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 оны уулын ажлын байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Улз групп” ХХК-ийн Өлийн гол-1 алтны шороон ордын ил уурхайн хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангах зорилготой. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Улз групп” ХХК-ийн байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг хариуцлагыг тодорхойлох зорилготой.

№	БОМТ ангилал	Төсөв, төг ₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6 500 000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	10 115 000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3 800 00
4	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	500 000
5	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	8 500 000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,654,300
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500 000
Нийт		35,569,300

5.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тоосжилтыг бууруулах зам, талбайн усалгаанд уурхайн худаг, гадаргын болон шүүрлийн ус, болон стандартын шаардлага хангасан саарал усыг ашиглана. Мөн уурхай болон хөрсний овоолгын ачаалал ихтэй, тоосжилт ихээр үүсгэж буй зам талбайг тодорхойлж техникийн хөдөлгөөнөөр тоос бага үүсгэдэг материалын дэвсэлт хийнэ.

Аюулгүй ажиллагааг хангах халтиргаа гулгаанаас сэргийлэх зорилгоор зам талбайн арчилгааг тогтмол хийх, зам талбайн усалгаанд газрын доорх усыг аль болох бага, хур тунадсаар газрын гадаргад хуримтлагдсан усыг түлхүү ашиглахыг зорино.

Сар бүр уурхайн хөдөлгөөнт техникүүдэд хяналт шалгалтыг Уурхайн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүдийн хамтаар тогтмол хийж гүйцэтгэн бүртгэл хөтөлж зөвшөөрөгдсөн хэмжээнээс хурд хэтрүүлсэн ажилтнуудад арга хэмжээ авч нийтэд мэдээлэх байдлаар хурдны хязгаарыг байнга мөрдүүлж ажиллана.ы

Хүснэгт 1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Мот/цаг, засвар үйлчилгээ	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
		Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тогтмол усалж байна.	Дотоод тээврийн зам, биологийн нөхөн сэргээлтийн талбай	Нэгж усалгаа	1 000 000		
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайд ашиглагдаж буй замууд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		

	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон		
	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Дотоод үйл ажиллагааны зардалд		
	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Уурхайн хэмжээнд		500 000		
	Агаарын тоосжилтийн 7 хоног бүр хэмжих багажтай болох	Уурхайн хэмжээнд		Дотоод зардлаар		
Нийт			1 500 000			

Гадаргын ба газрын доорх усны нөөц: Газар доорх усны бохирдол үүсэхээс хамгаалж худгийн хийц, хамгаалах байр зэргээр тоноглож, худаг, уст цэгт засвар үйлчилгээ хийж ажиллана.

Худагт байршуулсан усны тоолуур гэмтэх, эвдрэх, тоолуурын гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд сумын Байгаль орчны улсын байцаагчид мэдэгдэж, түүний хяналтан дор лацыг хөндөж, засвар үйлчилгээг хийх, стандарт хэмжилзүйн газраар баталгаажилт хийлгэсэн тоолуурыг суурилуулна. Ус ашиглагч болон байгаль орчны улсын байцаагч нарыг байлцуулан акт үйлдэж баталгаажуулсан байна. Засвар үйлчилгээ хийх явцад худагас зайлшгүй ус авч ашиглах тохиолдолд усны машины рейсийг үнэн зөв бүртгэж сар бүрийн усны актад тусгана. Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж дүгнэлтэд заагдсаны дагуу холбогдох гэрээг байгуулж төлбөрийг сар бүрийн тоолуурын заалтыг сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулж төлбөрийг тогтмол хугацаанд нь төлсөн байна.

Сав газрын захиргаанаас хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авч, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулан улирал бүрийн дүгнэлтийг үндэслэн зохих төлбөрийг улирал бүр төлнө.

Зам усалгаанд ашиглаж байгаа газар доорх усны хэмжээг бууруулах зорилгоор борооны усаар хуримтлагдсан усыг тоос бууруулах зориулалтаар түлхүү ашиглана.ы

Хүснэгт 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Уурхайн ашиглалтын худаг болон нөлөөллийн бүсийн худгуудад усны түвшний хэмжилтыг тогтмол хийх	Дотоод үйл ажиллагааны зардалд	Сард 2 удаа Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх - Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	1 500 000		
		Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Дотоод үйл ажиллагааны зардалд		
		Ахуйн хэрэглээний худгийн эрүүл ахуйн бүсийг тогтоож зориулалтын байртай болгох	Дотоод үйл ажиллагааны зардлаар		
Нийт		1500 000			

Хөрс, ургамал бүрхэвч: Уурхайн ахилт, зам талбай болон, хөрсний овоолгод хийгдэх ажлын үеийн шимт хөрсийг хуулж стандартын дагуу хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ. Тус ажлыг гүйцэтгэхдээ “Өнгөн хөрстэй ажиллах журам” мөн тухайн жилийн газар хөндөх болон, шимт хөрс хуулах зөвшөөрлийн бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж хадгална.

Уурхайн ахилт, зам талбай, хөрсний овоолгын тэлэлтийн шимт хөрс хуулах ажлыг батлагдсан маягтын дагуу олгож, олгосон зөвшөөрлийн дагуу бүртгэлийг хийж, хяналт тавьж ажиллана.

Асгаралт гарсан тохиолдолд нөлөөллийг хязгаарлах, орчин тойрныг бохирдуулахгүй байхад бэлэн байх нөхцөлийг хангаж асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгана.

Хүснэгт 3. Газрын хэвлий болон хөрсөнд бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, нийт зардал /төг/			Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3.	Газрын хэвлий Хөрсөн бүрхэвч	Олон салаа зам гарахаас сэргийлэх, шороон замын батлагдсан маршрутыг мөрдөх	Уурхай, хотхоны бүсэд,			Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Уурхайн хуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих ургамалжуулах зардал, нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглаж буй тооцоог хянах, бүртгэл хөтлөх	Шимт хөрсний овоолго	Хөтөлсөн бүртгэл	200 000	2026 онд	
		Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Засвар үйлчилгээний талбай	Бохирдсон талбай, асгарсан тос масло	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	
		Хөлрөлт, гоожилт үүсэхээс урьдчилэн сэргийлж шатахуун хадгалах савны холболтуудыг сольж шинэчлэх	Уурхайн талбай	Хөрс, ургамал бохирдохоос сэргийлэх	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Төслийн хугацаанд	
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг	Засварын талбай, авто	Саармагжуулах материал	2 300 000	Төслийн хугацаанд	

	саармагжуулан бохирдсон хөрсийг зогсоол, саармагжуулан бохирдолгүй болгох карьер				
Нийт	2 500 000				

Хүснэгт 4. Ургамал бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Ургамлан нөмрөг болон амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхай, хотхон	-		Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль
		Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	Олгосон зөвшөөрөл, бүртгэл	Дотоод үйл ажиллагааны зардал		
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхон, засварын талбайд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	1 000 000	Уурхайн хотхонд	
		Газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх	Уурхайн хэмжээнд				
			1 000 000				
НИЙТ ТӨСӨВ			Сөрөг нөлөөллийн бууруулах нийт зардал 6 500 000				

5.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны олборлолтын үйл ажиллагаагаар нийт 13.8 га газар эвдрэлд өртөх ба 2026 онд 3.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 1.5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөв. Биологийн нөхөн сэргээлтийг өөрсдийн хүн хүчээр мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авч хийх бөгөөд нөхөн сэргээлтийн стандартын дагуу нөмөрлөгч болон олон наст малын идэмж сайн ургамлын үрийг тариална. Биологийн нөхөн сэргээлтийн зардалд ургамлын үр худалдаж авах зардлыг тусгасан болно.

✓ Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

✓ Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налууугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

✓ Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	га	3.2	-	Үйл ажиллагааны зардлаар	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”
2.	Биологийн нөхөн сэргээлт	га	1.5	2743333	4 115 000	
3.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	1 000	6 000	6 000 000	
	Нийт				10 115 000	

5.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Архангай аймгийн байгаль орчны газраас ирсэн 2026.01.22 №10 дугаартай саналын дагуу дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажилдаа ховор ургамал болох Баягзагваа (Төвд ланцай) ургамлыг хашиж хамгаалах арга хэмжээг авахаар төлөвлөгөөндөө нэмэлтээр оруулж байна. Хашаажуулах ажлыг компанийн ажилчид өөрсдөө гүйцэтгэх бөгөөд хашаа худалдаж авах зардал болох **8 500 000** төг төлөвлөн оруулж байна.

5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

5.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Улз групп” ХХК-ийн “Өлийн гол”-ын алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Цэнхэр сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардал **500 000** төг төсөвлөсөн.

5.6. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

5.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна. Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах арга хэмжээг тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал	500 000	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн шингэн хаягдалд бохир усны химийн шинжилгээ хийлгэх	Орчны хяналт шинжилгээний ажилд орсон	5,8-р сард	
		Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна. Ахуйн хатуу хаягдал ялгаж хаях сав 500-1000 кг хог хаях багтаамжтай 4-6 тасалгаатай сав байна.	2 300 000	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг бүрэн ажилд оруулах	1 000 000	Үйл ажиллагааны турш	
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож орон нутагт улирал тутамд мэдээлж байна.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
2.	Үйлдвэрийн	Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслыг сар бүр тусгайлсан саванд хуримтлуулна. Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	
		Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах шатах тослох материалын үлдэгдэл, арчих материалын хаягдлыг хаягдал зайлуулах газарт шилжүүлэн хаяна.	Дотоод үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	

3	Бүх нийтийн цэвэрлэгээ	Захирлын тушаалын дагуу уурхайн хэмжээнд сард 2 удаа бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж явуулах	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны туршид	
4	Эмнэлгийн хог хаягдал	Уурхайн эмнэлгийн хог хаягдлыг сумын эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулан устгуулах	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагааны туршид	
Нийт зардал 3 800 000					

5.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2026 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Нөхөн сэргээлт хийсэн талбай, Засварын талбай ажилчдын хотхон, уурхайн карьерь, уурхайн зам	5,8-р саруудад нэг удаа	5 цэгт 2 удаа	60 000	600 000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO ₂ ын агууламж, Хүнд металл тодорхойлох, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, биологийн нөхөн сэргээлтийн талбай, засварын газар, ШТС орчим	5,8-р саруудад нэг удаа	5 цэгт 2 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 1-2 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 35000 төг Газарзүйн хүрээний Хөрсний лаборатрид Хөрсний хүнд	800 000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

					металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг “Ханлаб” лаборатори			
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, ахуйн хаягдал ус, Нөлөөллийн бүсийн худаг	5,6,7,8,9-р саруудад нэг удаа	5 цэгт 5 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ Мөн элс угаан баяжуулах нуурын усанд хүнд металлын шинжилгээ өгнө.	3 542 500	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.

	Бохирын нуурны хагшаасны шинжилгээ	5-р сард	1 цэгт 1 удаа	Геоэкологийн хүрээлэн	145000	Технологийн хэрэглээний усны тунгалагших шинж чанарт шаварны үзүүлэх нөлөөллийг тогтоох	
	Уурхайн дээд хэсэг болон доод хэсгээс дээж авч харьцуулах	5, 8-р сард	2 цэгт 2 удаа	141700	566 800	Уурхайн дээд хэсэг болон уурхайн доод хэсгийн усны өөрчлөлтийг харьцуулан уурхайн нөлөөллийг тогтоох	
	Мэргэжлийн байгууллагаар хийлгэх						
	НИЙТ				5,654,300		

5.9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод үйл ажиллагааны зардал	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Дотоод үйл ажиллагааны зардал	11-р сар	“Улз групп” ХХК-ийн удирдлагууд
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	Дотоод үйл ажиллагааны зардал	Сар бүр	“Улз групп” ХХК-ийн удирдлагууд

5.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 8. Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1.	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	9-р сард	500 000	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.
2.		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11 сарын 1-нд багтаан		
3.		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.	10-р сараас 12-р сарын 1-нд багтаан		